

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 24 оны 05 сарын 21 өдөр

№ R-2024-26

Улаанбаатар хот

Холбогдох этгээдийн болон сонирхлын  
зөрчилтэй хэлцлийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, ХасБанк ХК (“Банк”)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-48 дугаар тогтоолоор батлагдсан Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн, Банкны ТУЗ-ийн 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан цахим санал хураалтын үр дүнд дараах шийдвэрийг гаргав:

## ТЭМДЭГЛЭХ нь:


- Банкны ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо (“ЭУХ”) нь 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан цахим санал хураалтын үр дүнд, Банкны эрх бүхий албан тушаалтанд олгох, энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөл бүхий 10,000,000 (арван сая) төгрөгийн үнийн дүнтэй зээл (“Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл”)-ийг Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3 дахь заалт, 4.3 дахь хэсэгт заасны дагуу батлах саналыг ТУЗ-д хүргүүлснийг;
- Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь аливаа хөнгөлөлттэй нөхцөлгүй, банкны өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд харилцагчдад санал болгож буй ердийн нөхцөлөөс давуу тал олгоогүй болохыг ЭУХ тодорхойлсон болохыг; мөн
- ТУЗ нь ЭУХ-ноос санал болгосны дагуу Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

- Тогтоолын хавсралтад заасан Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсугай.
- Хэлцлийн нөхцөлд аливаа материаллаг өөрчлөлт ороход ТУЗ-д танилцуулж батлуулахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ